



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/114/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мандалговь хот 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Должинсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: Doljinsuren@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
4.1 Залруулсан алдаа	12
4.3 Албан шаардлага	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.02.25 № 36

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ХУЛД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
С.СҮХДОРЖ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хулд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хулд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ 012020765

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	49,881,451.56	77,321,942.56
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	60.00	0.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	60.00	0.00
31110	Төгрөг	60.00	0.00
33	АВЛАГА	0.00	699,298.00
33500	Бусад авлага	0.00	699,298.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	699,298.00
35	БАРАА МАТЕРИАЛ	49,881,391.56	76,622,644.56
35100	Түүхий эд материал	1,974,832.00	10,383,450.00
35110	Тусгай зориулалттай материал	1,974,832.00	10,383,450.00
35400	Хангамжийн материал	47,906,559.56	66,239,194.56
35410	Бичиг хэргийн материал	0.00	372,500.00
35420	Аж ахуйн материал	47,906,559.56	63,966,694.56
35450	Барилгын засварын материал	0.00	1,900,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	965,959,962.81	923,681,686.41
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	965,959,962.81	923,681,686.41
39200	Биет хөрөнгө	942,358,083.24	901,446,806.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	925,104,321.43	952,166,821.43
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(149,599,413.22)	(187,292,716.06)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	157,310,150.00	157,310,150.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(99,466,074.08)	(116,279,936.12)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	121,205,627.80	123,645,627.77
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(60,467,806.14)	(82,253,060.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,193,053.50	70,793,053.50
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(31,312,537.48)	(40,395,067.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,644,840.00	31,335,540.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(6,254,078.57)	(7,583,606.41)
39300	Биет бус хөрөнгө	23,601,879.57	22,234,879.77
39301	Програм хангамж	6,910,000.00	6,910,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(2,758,120.43)	(4,125,120.23)
39303	Бусад биет бус хөрөнгө	19,450,000.00	19,450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1,015,841,414.37	1,001,003,628.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	60.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	60.00	0.00
41300	Өглөг	60.00	0.00
41360	Бусад өглөг	60.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	60.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1,015,841,354.37	1,001,003,628.97
51	Засгийн газрын хувь оролцоо	1,015,841,354.37	1,001,003,628.97
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	318,248,222.10	318,248,222.10
51200	Хуримтлагдсан үр дүн	368,510,052.43	353,672,327.03
51210	Өмнөх үеийн үр дүн	368,510,052.43	368,510,052.43
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	(14,837,725.40)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	329,083,079.84	329,083,079.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1,015,841,414.37	1,001,003,628.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	469,488,037.00	506,814,453.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	91,713,814.00	76,515,669.97
1200	Нийтлэг татварын бус орлого	91,713,814.00	76,515,669.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	205,300.00

1200042	Туслах үйл ажиллагааны орлого	0.00	205,300.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	89,479,264.00	44,613,199.97
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	2,234,550.00	31,697,170.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	377,774,223.00	430,298,784.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,546,123.00	61,683,284.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	620,000.00	15,122,443.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	26,594,628.00	33,248,156.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,331,495.00	13,312,685.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	347,228,100.00	368,615,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	347,228,100.00	368,615,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	469,241,339.73	521,652,179.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	469,241,339.73	521,652,179.37
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	446,114,625.62	465,174,650.10
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	234,103,766.68	207,288,399.08
210101	Үндсэн цалин	186,857,366.68	161,979,997.93
210102	Нэмэгдэл	26,479,900.00	45,308,401.15
210105	Гэрээт ажлын цалин	20,766,500.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,913,084.22	25,777,431.96
210201	Тэтгэврийн даатгал	17,556,441.84	17,530,931.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,098,410.71	2,099,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,678,869.32	1,683,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	416,242.13	405,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,163,120.22	4,058,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,669,612.99	23,500,937.89
210301	Гэрэл, цахилгаан	7,357,132.99	6,098,947.09
210302	Түлш, халаалт	8,312,480.00	15,599,590.80
210303	Цэвэр, бохир ус	0.00	1,802,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,048,230.80	32,145,690.00
210401	Бичиг хэрэг	2,960,100.00	3,408,210.00
210402	Тээвэр, шатахуун	19,076,848.00	21,916,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,422,000.00	2,215,000.00
210404	Ном, хэвлэл	0.00	288,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	48,000.00	2,687,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,931,283.80	1,631,140.00
210408	Бараа материал актласны зардал	609,999.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,664,385.00	16,233,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	314,600.00	0.00
210604	Урсгал засвар	7,349,785.00	16,233,650.00
2107	Томилолт, зочны зардал	5,488,000.00	3,252,000.00
210702	Дотоод албан томилолт	5,488,000.00	3,252,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,233,314.00	1,937,020.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,974,480.00	970,176.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,525.00	469,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,940.00	147,844.80
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	390,000.00	245,000.00
210807	Газрын төлбөр	104,369.00	105,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	99,994,231.93	155,039,520.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,135,418.00	64,604,044.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	720,000.00	2,364,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	86,138,813.93	88,071,476.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,126,714.11	56,477,529.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,818,500.00	38,560,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	4,275,000.00

213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	146,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,322,500.00	33,165,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000.00	1,120,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,308,214.11	17,917,229.27
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,308,214.11	17,917,229.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	246,697.27	(14,837,725.40)
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	2,512,216.50	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	2,512,216.50	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,512,216.50	0.00
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(2,265,519.23)	(14,837,725.40)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	318,248,222.10	329,083,079.84	370,775,571.66	1,018,106,873.60
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	318,248,222.10	329,083,079.84	370,775,571.66	1,018,106,873.60
7	Өмчид гарсан өөрчлөлт			(2,265,519.23)	(2,265,519.23)
8	Зарласан ноогдол ашиг	318,248,222.10	329,083,079.84	368,510,052.43	1,015,841,354.37
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	318,248,222.10	329,083,079.84	368,510,052.43	1,015,841,354.37
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	318,248,222.10	329,083,079.84	368,510,052.43	1,015,841,354.37
19	Тайлант үеийн үр дүн			(14,837,725.40)	(14,837,725.40)
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	318,248,222.10	329,083,079.84	353,672,327.03	1,001,003,628.97

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	377,774,223.00	430,504,084.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		205,300.00
1200	Нийтлэг татварын бус орлого		205,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		205,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого		205,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	377,774,223.00	430,298,784.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,546,123.00	61,683,284.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	620,000.00	15,122,443.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	26,594,628.00	33,248,156.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,331,495.00	13,312,685.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	347,228,100.00	368,615,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	347,228,100.00	368,615,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	372,074,165.00	430,504,144.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	372,074,165.00	430,504,144.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	348,947,450.89	374,026,614.73
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	234,103,766.68	207,987,697.08
210101	Үндсэн цалин	186,857,366.68	162,679,295.93
210102	Нэмэгдэл	26,479,900.00	45,308,401.15
210105	Гэрээт ажлын цалин	20,766,500.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,913,084.22	25,777,431.96
210201	Тэтгэврийн даатгал	17,556,441.84	17,530,931.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,098,410.71	2,099,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,678,869.32	1,683,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	416,242.13	405,800.00

Хулд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	4,163,120.22	4,058,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,499,512.99	23,500,937.89
210301	Гэрэл, цахилгаан	7,357,132.99	6,098,947.09
210302	Түлш, халаалт	5,142,380.00	15,599,590.80
210303	Цэвэр, бохир ус		1,802,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,296,948.00	36,517,025.00
210401	Бичиг хэрэг	2,960,100.00	3,780,710.00
210402	Тээвэр, шатахуун	19,076,848.00	21,916,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,422,000.00	2,215,000.00
210404	Ном, хэвлэл		288,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	48,000.00	2,687,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,790,000.00	5,629,975.00
2105	Нормативт зардал		90,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		90,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,664,385.00	21,450,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	314,600.00	
210604	Урсгал засвар	7,349,785.00	21,450,950.00
2107	Томилолт, зочны зардал	5,488,000.00	3,252,000.00
210702	Дотоод албан томилолт	5,488,000.00	3,252,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,233,314.00	1,937,020.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,974,480.00	970,176.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	96,525.00	469,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,940.00	147,844.80
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	390,000.00	245,000.00
210807	Газрын төлбөр	104,369.00	105,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,748,440.00	53,513,552.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,028,440.00	51,149,552.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	720,000.00	2,364,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,126,714.11	56,477,529.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,818,500.00	38,560,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		4,275,000.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	146,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,322,500.00	33,165,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000.00	1,120,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,308,214.11	17,917,229.27
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,308,214.11	17,917,229.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	5,700,058.00	(60.00)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,699,998.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,699,998.00	
223	БУСАД ХӨРӨНГӨ	5,699,998.00	
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,699,998.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(5,699,998.00)	
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	60.00	(60.00)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		60.00
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	60.00	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		60.00
11100	Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл		
11200	Кассын оны эхний үлдэгдэл		60.00
12	Татварын бус орлого	368,615,500.00	360,731,869.88
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/		205,300.00
122005	Төсвөөс санхүүжих	368,615,500.00	360,526,569.88
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	368,615,500.00	360,731,929.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	368,615,500.00	360,731,929.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330,330,200.00	322,671,629.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,215,000.00	207,987,697.08
210101	Үндсэн цалин	155,317,100.00	162,679,295.93
210102	Нэмэгдэл	54,897,900.00	45,308,401.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,053,400.00	25,777,431.96
210201	Тэтгэврийн даатгал	18,806,900.00	17,530,931.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,099,000.00	2,099,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,683,200.00	1,683,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	405,800.00	405,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,058,500.00	4,058,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,449,700.00	20,482,556.04
210301	Гэрэл, цахилгаан	5,550,000.00	4,882,965.24
210302	Түлш, халаалт	18,899,700.00	15,599,590.80
2104	Хангамж, бараа материалын зардал	24,916,100.00	24,916,100.00
210401	Бичиг хэрэг	2,672,000.00	2,672,000.00
210402	Тээвэр, шатахуун	13,274,100.00	13,274,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,965,000.00	1,965,000.00
210404	Ном, хэвлэл	288,000.00	288,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,687,000.00	2,687,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,030,000.00	4,030,000.00
2105	Нормативт зардал	90,000.00	90,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	90,000.00	90,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,274,000.00	19,274,000.00
210604	Урсгал засвар	19,274,000.00	19,274,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,264,000.00	3,252,000.00
210702	Дотоод албан томилолт	3,264,000.00	3,252,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	1,143,000.00	966,844.80
210803	Даатгалын үйлчилгээ	469,000.00	469,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,000.00	147,844.80
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	45,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	331,000.00	245,000.00
210807	Газрын төлбөр	105,000.00	105,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,925,000.00	19,925,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,311,000.00	19,311,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	614,000.00	614,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,285,300.00	38,060,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,500,000.00	4,275,000.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,165,300.00	33,165,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	620,000.00	620,000.00
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
12100	Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл		
12200	Тусламжийн орлого	368,615,500.00	360,526,569.88
12200	Кассын дансны эцсийн үлдэгдэл		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	61,683,284.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,683,284.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,354,984.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,018,381.85
210301	Гэрэл, цахилгаан	1,215,981.85
210303	Цэвэр, бохир ус	1,802,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,600,925.00
210401	Бичиг хэрэг	1,108,710.00
210402	Тээвэр, шатахуун	8,642,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,599,975.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,176,950.00
210604	Урсгал засвар	2,176,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	970,176.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	970,176.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,588,552.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,838,552.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1,750,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,328,299.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,828,299.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,828,299.15
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	61,683,284.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	61,683,284.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61,683,284.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,122,443.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	33,248,156.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,312,685.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
11000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Должинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын Тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 3/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын Тамгын газар нь эрхэм зорилгоо “Төрийн хуулийг дээдлэн, ил тод, төвийг сахисан, нягт нямбай, зарчимч ажиллаж олон түмний итгэл хүндэтгэлийг даан төрийн ажилтны нэр хүндийг өндөрт өргөж иргэн бүрд тэгш шударга үйлчлэхэд бидний эрхэм зорилго оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны 6 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн, 1 албан шаардлага, 6 зөвлөмж хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 4 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 4 дүгээр улирлын нийт хөрөнгийн 1,001,003.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,001.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,000.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,837.8 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан хөрөнгийн данс нь эргэлтийн бус хөрөнгийн данс бөгөөд 42,278.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн данс нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	49,881.5	77,321.9	27,440.5
МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.1	-	-0.1
АВЛАГА	-	699.3	699.3
БАРАА МАТЕРИАЛ	49,881.4	76,622.6	26,741.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	965,960.0	923,681.7	-42,278.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	965,960.0	923,681.7	-42,278.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1,015,841.4	1,001,003.6	-14,837.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	0.1	-	-0.1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1,015,841.4	1,001,003.6	-14,837.7
Засгийн газрын хувь оролцоо	1,015,841.4	1,001,003.6	-14,837.7
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1,015,841.4	1,001,003.6	-14,837.8

Бараа материал дансны үлдэгдэл 76,622.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 26,741.3 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материалын өсөлт байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 580.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 600.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 42,753.2 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, 1,360.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар авсан байна. Мөн 88,071.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,001,003.6 мянган төгрөг болж 14,837.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн буурснаас шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 343,852.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 343,852.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 7,013.2 мянган төгрөгөөр өсгөн 350,865.5 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн өсөлт нь цар тахлын үеийн бэлэн байдлын зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой. Төсвийн тодотголоор 17,750.0 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын урьд оны үлдэгдлээс нэмж тодотгосон.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 368,615.5 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 368,615.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд нийт төсвийн 97.8 хувийг зарцуулж, 8,088.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 360,526.5 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын гүйцэтгэл буюу батлагдсан орон тооноос дутуу үйл ажиллагаагаа явуулсантай болон халаалтын зардал хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 33,248.2 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс авсан хандив, тусламжаар 15,122.4 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 13,312.7 мянган төгрөг, нийт 61,683.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс үйл ажиллагааны зардалд 51,855.0 мянган төгрөгийг зарцуулж, 9,828.3 мянган төгрөгийг орон нутгийн орлогод буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Нэмэлт санхүүжилтийн дансанд ковидын нөхцөл байдал болон хаврын шороон шуурганы аюултай үзэгдэлд хүнд гарз хохирол амссан сумын иргэдэд тухайн нутагт зам ашигласан 1 компани 10,000.0 мянган төгрөг, нутгийн иргэд 5,122.4 мянган төгрөгийн хандивыг өгсөн байна. Тухайн хандивын мөнгийг сумын элсэн шороог түрсэн машины шатахуун ажлын хөлсөнд зарцуулж, үлдэгдэл 9,828.3 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд нийт 385,624.4 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулахаас 23 мэдээллийг хугацаа хоцроож, хэрэгжилт 86 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зөрчсөн 2,100.0 мянган төгрөгийн дараах зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,134.1 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,412.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,180.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,232.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Шинээр худалдаж авсан 1,180.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 4,232.0 мянган төгрөгийн зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тэмдэглэлт ой, урлагийн наадам, уралдаан тэмцээнд 2,100.0 мянган төгрөгийг зарцуулсан.
2. Хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдэл болон Төрийн нууц хамгаалах чиг үүргийг хариуцах ажилтанд олгох нэмэгдлийг 2,132.0 мянган төгрөгөөр илүү олгосон.

Шийдвэрлэсэн нь: Хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн агуулга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Тэмдэглэлт ой, урлагийн наадам, уралдаан тэмцээнд 2,100.0 мянган төгрөгийг зарцуулсан.	1	2,100.0					1	2,100.0		
	Дүн	1	2,100.0					1	2,100.0		
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд олгох нэмэгдэл болон Төрийн нууц хамгаалах чиг үүргийг хариуцах ажилтанд олгох нэмэгдлийг 2,131.9 мянган төгрөгөөр илүү олгосон	1	2,131.9					1	2,132.0		
2	Шинээр худалдаж авсан 1,180.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн	1	1,180.0	1	1,180.0						
	Дүн	2	3,311.9	1	1,180.0			1	2,132.0	0	0
	Нийт дүн	3	5,412.0	1	1,180.0			2	2,132.0	0	0